

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДААТГАЛЫН ГАЗАР**

**ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН 2012 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ
2012.04.30

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

- 1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
- 1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ
- 1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 1.6 ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- 1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА
- 1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 1.9 ДАВХАР ДААТГАЛ

ХОЁРДУГААР БҮЛЭГ.ЕРДИЙН ДААТГАЛ

- 2.1 ЕРДИЙН ДААТГАЛ
- 2.2 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ
- 2.3 ЕРДИЙН ДААТГАЛЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 2.4 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 2.5 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 2.6 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- 2.7 ЕРДИЙН ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА
- 2.8 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 2.9 ЕРДИЙН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ
- 2.10 МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСАН ДААТГАЛЫН ТАЛААР

ГУРАВДУГААР БҮЛЭГ.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

- 3.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ
- 3.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨР
- 3.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГ, НӨӨЦ САН

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

- 4.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ
- 4.2 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ
ДҮГНЭЛТ

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН 2012 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2012 оны 1 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр 18 даатгалын компани, 190 даатгалын төлөөлөгч, 10 даатгалын зуучлагч, 9 даатгалын хохирол үнэлэгч, 15 актуарч, нийт 2079 даатгалын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчид үйл ажиллагаа явуулсан дүнтэй байна (Хүснэгт-1).

Хүснэгт-1

Даатгалын зах зээл дээрх тусгай
зөвшөөрөл, эрх эзэмшигчид, тоогоор

№	Үзүүлэлт	2009-1	2010-1	2011-1	2012-1
1	Даатгагч	16	17	17	18
2	Даатгалын компанийн салбар	120	131	139	190
3	Даатгалын төлөөлөгч	1167	1874	1592	2079
4	Даатгалын зуучлагч	4	6	9	10
5	Даатгалын хохирол үнэлэгч		3	7	9
6	Актуарч	9	10	12	15
	БҮГД	1316	2041	1776	2321

Хорооны 2012 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор “Хашхаан” ХХК-д ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, Хорооны 2012 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 57 дугаар тогтоолоор “Юу ай би” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл тус тус олгосон байна.

График-1




Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд, хувь хүмүүсийн тоо 2009 оны 1 дүгээр улирлаас хойш 1005 тусгай зөвшөөрөл эзэмшигчдээр өссөн байна. (График-1).

1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

2012 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын зах зээл дээр урт хугацааны болон ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын нийт хөрөнгө 84.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 26.0 тэрбум төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн байна.

Сүүлийн 5 жилийн мөн үеийн байдлаарх даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ жилд дунджаар 25.7%-иар өссөн бөгөөд 2007 оны 1 дүгээр улиралд 28.4 тэрбум төгрөг байсантай харьцуулахад 3 дахин өссөн дүнтэй байна. (График-2).



2012 оны 1 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн болон урт хугацааны даатгалын компаниудыг нийт хөрөнгийн хэмжээгээр жагсаахад эхний 1 компани нийт хөрөнгийн 22.4 хувийг, эхний 3 компани нийт хөрөнгийн 39.4 хувийг тус тус эзэлж байна. Энэ нь даатгалын зах зээл дэх хөрөнгийн төвлөрлийн хэмжээ өндөр байгааг харуулж байна (Хүснэгт-2).

Даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	5,438.9	6.4
2	Бодь даатгал ХХК	7,616.4	9.0
3	Ган зам даатгал ХХК	1,634.8	1.9
4	Мандал женерал даатгал ХХК	6,771.2	8.0
5	Жонон даатгал ХХК	1,412.7	1.7
6	МИГ даатгал ХХК	5,523.9	6.5
7	Монгол даатгал ХХК	18,893.1	22.4
8	Гэрдаатгал ХХК	1,713.5	2.0
9	Моннис даатгал ХХК	2,298.0	2.7
10	Мөнх даатгал ХХК	1,999.2	2.4
11	Номин даатгал ХХК	4,256.8	5.0
12	Нэйшнл лайф даатгал ХХК	3,560.0	4.2
13	Практикал даатгал ХХК	5,593.8	6.6
14	Тэнгэр даатгал ХХК	5,804.6	6.9
15	Соёмбо даатгал ХХК	5,354.3	6.3
16	Монре даатгал ХХК	2,396.4	2.8
17	УБ хотын даатгал ХХК	2,140.5	2.5
18	Хаш хаан даатгал ХХК	2,000.0	2.4
	ДҮН	84,408.1	100.0

Эргэлтийн хөрөнгийн бүтэц

Эргэлтийн хөрөнгө тайлант улиралд өмнөх оны мөн үеийнхээс 18432.4 сая төгрөгөөр өсч, нийт 67394,1 сая төгрөгт хүрсэн байна.

Эргэлтийн хөрөнгийг бүтцээр нь авч үзвэл 2012 оны 1 дүгээр улиралд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ 37056.3 сая төгрөг ба нийт эргэлтийн хөрөнгийн 57.95 хувь, богино хугацаат хөрөнгө оруулалт 18540.5 сая төгрөг буюу нийт эргэлтийн хөрөнгийн 27.51 хувь, дансны авлага 8605.5 сая төгрөг ба нийт эргэлтийн хөрөнгийн 12.77 хувь, бусад эргэлтийн хөрөнгө 1191.8 сая төгрөг ба нийт эргэлтийн хөрөнгийн 1.77 хувийг тус тус эзэлж байна. /Хүснэгт-3/

/Хүснэгт-3/

/сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2010-1 улирал		2011-1 улирал		2012-1 улирал	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	23,496.00	66.00	32,765.70	66.92	39,056.30	57.95
Богино хугацаат хөрөнгө оруулалт	6,572.70	18.46	10,251.80	20.94	18,540.50	27.51
Дансны авлага	4,390.00	12.33	5,295.60	10.82	8,605.50	12.77
Бусад эргэлтийн хөрөнгө	1,140.00	3.20	648.60	1.32	1,191.80	1.77
Эргэлтийн хөрөнгийн дүн	35,598.70	100.00	48,961.70	100.00	67,394.10	100.00

Тайлант улиралд өмнөх оны мөн үеийнхээс эргэлтийн хөрөнгөнд эзлэх мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ 8.97 пунктээр буурч, богино хугацаат хөрөнгө оруулалт 6.6 пунктээр, дансны авлага 1.95 пунктээр, бусад эргэлтийн хөрөнгө 0.45 пунктээр тус тус өссөн байна.

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгийн үзүүлэлтүүдээс мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, хөрөнгө оруулалтууд ихээхэн хувийг эзэлсэн байна. “Богино хугацаат хөрөнгө оруулалт” гэдэг ойлголтонд 3 сараас дээш хугацаатай банкны хугацаат хадгаламжууд хамрагддаг учраас эргэлтийн хөрөнгийн ихэнх хэсгийг үндсэндээ мөнгөн хөрөнгө бүрдүүлж байгаа юм.

1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн бүтцийг сүүлийн 5 жилийн 1 дүгээр улирлын байдлаар дүгнэж үзэхэд 2008 оны 1 дүгээр улиралд даатгалын нөөц сан 63,0 хувийг эзэлж байсан бол 2009 оны 1 дүгээр улиралд 43,0 хувь, 2010 оны 1 дүгээр улиралд 58,5 хувь, 2011 оны 1 дүгээр улиралд 49,5 хувь, 2012 оны мөн үед 44.1 хувь болж тус тус буурсан байна.

Даатгалын компанийн балансын нийт пассивт нөөц сангийн эзлэх хувь 2010 оноос хойш буурч, харин эзэмшигчийн өмчийн эзлэх хувь өссөн бөгөөд энэ нь нэг талаас хувь нийлүүлэгчийн хөрөнгө буюу дүрмийн сангийн өсөлт, нөгөө талаас даатгалын нөөц сангийн актуар тооцоолол хангалтгүй байгаатай холбоотой. (График-4).

Өр төлбөр эзэмшигчдийн өмч, нөөц сангийн үзүүлэлт




График-4

Хүснэгт-4

Үзүүлэлт	2010-1 улирал	2011-1 улирал	2012 -1 улирал
Өр төлбөр	6.6	5.3	7.4
Нөөц сан	58.5	49.5	44.1
Эзэмшигчийн өмч	31.0	45.2	48.5
Нийт дүн	100.0	100.0	100.0

Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувь 2010 оны 1 дүгээр улиралд 31.0 хувь байсан бол 2011 оны 1 дүгээр улиралд 45.2 хувь, тайлант оны мөн үед 48.5 хувь болж тус тус өссөн бөгөөд 2012 оны 1 дүгээр улиралд 2010 оны мөн үеийнхээс 17.5 пунктээр өссөн байна.

2010 оны 1 дүгээр улиралд өр төлбөр 6.6 хувийг эзэлж байсан бол 2012 оны 1 дүгээр улиралд 7.4 хувийг эзэлж 2010 оны мөн үеийнхээс 0.8 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн даатгагч болон урт хугацааны даатгалын компанийн нийт орлого 17767.3 сая төгрөг байна. Үүний ердийн даатгалын хураамжийн орлого 17668.4 сая төгрөг, урт хугацааны даатгалын компанийн орлого 98.9 сая төгрөг байна.

Тайлант улиралд ердийн даатгалын компанийн давхар даатгалын хураамж 8054.6 сая төгрөг, буцаасан даатгалын хураамж 46.2 төгрөг, даатгалын цэвэр хураамжийн орлого 9567.6 сая төгрөгт хүрсэн байна. Урт хугацааны даатгалын

компанийн хувьд давхар даатгалын хураамж 2.5 сая төгрөг, даатгалын цэвэр хураамжийн орлого 96.5 сая төгрөг байна.

2012 оны 1 дүгээр улиралд даатгалын нийт хураамжийн орлогыг ердийн болон урт хугацааны даатгалын хэлбэрээр нарийвчлан харахад өмнөх оны мөн үеийнхээс хөрөнгийн даатгал 3279.1 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн даатгал 820.4 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 311.8 сая төгрөгөөр, гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал 704.6 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 1485.5 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 338.8 сая төгрөгөөр, тэтгэврийн даатгал 7.1 сая төгрөг, хуримтлалын даатгал 11.8 сая төгрөг, ачааны даатгал 25.4 сая төгрөгөөр, барилга угсралтын даатгал 200.9 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 13.0 сая төгрөгөөр тус тус өсч, нийт дүнгээр 8820.4 сая төгрөгөөр өмнөх оны мөн үеийнхээс өссөн үзүүлэлттэй байна. (Хүснэгт-5).

/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	2011.03.31	2012.03.31	Өөрчлөлт /+, -/	Цэвэр өөрчлөлт /хувиар/
	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)		
1.2. Хөрөнгийн даатгал	2153.1	5432.2	3279.1	152.3
1.3. Авто тээвэр хэрэгслийн даатгал	1923.5	2743.9	820.4	42.7
1.8. Агаарын хөлгийн даатгал	1022.3	2620.5	1598.2	156.3
1.10. Хариуцлагын даатгал	1985.8	2297.6	311.8	15.7
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	847.5	1552.1	704.6	83.1
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	381.1	1866.6	1485.5	389.8
1.11. Санхүүгийн даатгал	242.8	581.6	338.8	139.5
1.5. Барилга угсралтын даатгал	123.6	324.5	200.9	162.5
1.4. Ачааны даатгал	224	249.4	25.4	11.3
2.1. Хугацаат амьдралын даатгал	18.5	42.5	24.0	129.7
2.5. Эрүүл мэндийн даатгал	6.6	19.6	13.0	197.0
1.7. Мал амьтдын даатгал			0.0	
1.6. Газар тариалангийн даатгал			0.0	
2.3. Хуримтлалын даатгал	16.7	28.5	11.8	70.7
2.4 Тэтгэврийн даатгал	1.4	8.5	7.1	507.1
ДҮН	8 946.9	17 767.5	8 820.4	98,6

Даатгалын компаниудыг 2012 оны 1 дүгээр улиралд олсон даатгалын хураамжийн орлогын хэмжээгээр жагсаахад эхний 1 компани нийт хураамжийн орлогын 29.9 хувь, эхний 3 компани 58.8 хувийг тус тус бүрдүүлж ажилласан байна.

Даатгалын хэлбэрээр авч үзвэл ердийн даатгалын хувьд хөрөнгийн даатгал, агаарын хөлгийн даатгал, автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал,

барилга угсралтын даатгал зэрэг нь огцом өссөн буюу ойролцоогоор 2.5-4.9 дахин өсчээ.

Хамгийн өндөр өсөлттэй буюу жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийн орлогын өсөлтөд 2011 онд шинээр батлагдаж, 2012 оноос мөрдөгдөж эхэлсэн Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт нөлөөлсөн. Түүнчлэн улсын эдийн засгийн ерөнхий өсөлт, инфляци зэрэг нь өсөлтийн дараагийн хүчин зүйлүүд болж байна.

Урт хугацааны даатгалын эрүүл мэндийн, тэтгэврийн, хугацаат амьдралын даатгалын хураамжийн орлого харгалзан 2.9, 6.0, 2.3 дахин тус тус өссөн нь урт хугацааны даатгалын хамралт өссөнтэй холбоотой.

(Хүснэгт-6)

		/сая төгрөгөөр/	
	Даатгалын компаниуд	Даатгалын хураамжийн орлого	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	1,501.8	8.5
2	Бодь даатгал ХХК	3,363.7	18.9
3	Ган зам даатгал ХХК	205.7	1.2
4	Мандал генерал даатгал ХХК	382.7	2.2
5	Жонон даатгал ХХК	-	0.0
6	МИГ даатгал ХХК	1,779.0	10.0
7	Монгол даатгал ХХК	5,315.7	29.9
8	Гэр даатгал ХХК	9.9	0.1
9	Моннис даатгал ХХК	1,108.2	6.2
10	Мөнх даатгал ХХК	131.8	0.7
11	Номин даатгал ХХК	675.3	3.8
12	Нэйшнл лайф даатгал ХХК	98.9	0.6
13	Практикал даатгал ХХК	481.9	2.7
14	Тэнгэр даатгал ХХК	882.7	5.0
15	Соёмбо даатгал ХХК	964.9	5.4
16	Монре ХХК	736.9	4.1
17	УБ хотын даатгал ХХК	128.2	0.7
	ДҮН	17,767.3	100.0

1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2012 оны 1 дүгээр улиралд даатгалын компаниуд даатгуулагч иргэд, байгууллагуудад нийт 2951.6 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон ба үүнээс ердийн даатгагч 2910.2 сая төгрөг, урт хугацааны даатгагч 41.4 сая төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон байна.

Тайлант үед даатгалын нөхөн төлбөрийн дүн 44 хувиар өссөн хэдий ч даатгалын хураамжийн орлогын өсөлттэй харьцуулахад бага өсөлттэй гэж дүгнэхээр байна.

(Хүснэгт-7)

Даатгалын хэлбэр	2011.03.31	2012.03.31	Өөрчлөлт	Өөрчлөлт /хувиар/
	Даатгалын нийт нөхөн төлбөр(сая.төг)			
1.2. Хөрөнгийн даатгал	318.4	263.1	-55.30	-17.4
1.3. Авто тээврийн хэрэгслийн даатгал	951.8	1 485.1	533.30	56.0
1.8. Агаарын хөлгийн даатгал			0.00	
1.10. Хариуцлагын даатгал	135.6	37.1	-98.50	72,6
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	208.1	370.9	162.80	78.2
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	269.8	430.0	160.20	59.4
1.11. Санхүүгийн даатгал	118.0	294.4	176.40	149.5
1.5. Барилга угсралтын даатгал			0.00	
1.4. Ачааны даатгал	31.9	29.6	-2.30	-7.2
2.1. Хугацаат амьдралын даатгал	4.3		-4.30	
2.5. Эрүүл мэндийн даатгал	3.2		-3.20	
1.7. Мал амьтдын даатгал	5.8		-5.80	
1.6. Газар тариалангийн даатгал			0.00	
2.3. Хуримтлалын даатгал	2.1	16.0	-13.90	661,9
2.4 Тэтгэврийн даатгал	2 049.0	2 951.5	861.2	44.0

Тайлант оны 1 дүгээр улирлын даатгалын нөхөн төлбөрийг өмнөх оны мөн үеийнхтэй хэлбэр тус бүрээр харьцуулбал ердийн даатгалаас санхүүгийн даатгалын нөхөн төлбөр хамгийн өндөр өсөлттэй буюу 2,5 дахин, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1,8 дахин өссөн бол урт хугацааны даатгалын хувьд хуримтлалын даатгалын хэлбэрийн нөхөн төлбөр хамгийн өндөр өсөлттэй байсан байна.

2012 онд олгосон даатгалын нөхөн төлбөрийн 50.3 хувийг автотээврийн хэрэгслийн даатгалын, 14.6 хувийг жолоочийн хариуцлагын даатгалын нөхөн төлбөр тус тус эзэлж байна.

Автотээврийн хэрэгслийн даатгал 533.3 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 160.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол агаарын хөлгийн даатгал, газар тариалангийн даатгал, барилга усралтын даатгалаар тус тус нөхөн төлбөр олгогдоогүй байна.

Хүснэгт-8

	Даатгалын компаниуд	Даатгалын нөхөн төлбөр	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	246.6	8.4
2	Бодь даатгал ХХК	208.6	7.1
3	Ган зам даатгал ХХК	4.8	0.2
4	Мандал женерал даатгал ХХК	1.7	0.1
5	Жонон даатгал ХХК	-	0.0
6	МИГ даатгал ХХК	254.2	8.6
7	Монгол даатгал ХХК	1,267.1	42.9
8	Гэр даатгал ХХК	0.1	0.0
9	Моннис даатгал ХХК	31.4	1.1
10	Мөнх даатгал ХХК	12.0	0.4
11	Номин даатгал ХХК	173.4	5.9

12	Нэйшнл лайф даатгал ХХК	41.4	1.4
13	Практикал даатгал ХХК	171.0	5.8
14	Тэнгэр даатгал ХХК	225.4	7.6
15	Соёмбо даатгал ХХК	230.5	7.8
16	Монре даатгал ХХК	49.8	1.7
17	УБ хотын даатгал ХХК	33.5	1.1
	ДҮН	2,951.5	100.0

Даатгалын компаниудыг даатгалын нөхөн төлбөр олголтоор харьцуулахад “Монгол даатгал” ХХК 1267.1 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 42.9 хувийг эзэлж байсан бол “Жонон даатгал” ХХК даатгалын нөхөн төлбөр олгоогүй байна.

1.6 ДААТГАЛЫН ХОХИРОЛ НӨХӨЛТИЙН ХАРЬЦАА

Даатгалын хохирол нөхөлтийн харьцаа 2010 оны 1 дүгээр улиралд 33.1 хувь, 2011 оны 1 дүгээр улиралд 33.1 хувь байсан бол 2012 оны мөн үед 29.5 хувь болж өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 3.6 пунктээр буурсан байна. (График-10).

График-10



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын 2011 оны хохирол нөхөлтийн харьцааг 2012 оны 1 дүгээр улирлын үзүүлэлттэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт-9

Даатгалын хохирол нөхөлтийн харьцаа

№	Даатгалын компаниудын нэрс	Хохирол нөхөлтийн түвшин		Өсөлт бууралт /пунктээр/
		2011-01	2012-01	
1	Ард даатгал ХХК	41.3	24.5	-16.76
2	Бодь даатгал ХХК	24.6	21.5	-3.10
3	Ган зам даатгал ХХК	6.2	4.1	-2.13
4	Мандал женерал даатгал ХХК	6.2	1.2	-5.02
5	Жонон даатгал ХХК	69.9	0.0	-69.88
6	МИГ даатгал ХХК	31.5	24.9	-6.54

7	Монгол даатгал ХХК	44.7	45.7	0.99
8	Гэр даатгал ХХК	74.0	3.5	-70.54
9	Моннис даатгал ХХК		17.7	17.74
10	Мөнх даатгал ХХК	25.9	5.9	-19.97
11	Номин даатгал ХХК	32.0	31.5	-0.46
12	Нэйшнл лайф даатгал ХХК	36.3	42.9	6.63
13	Практикал даатгал ХХК	11.2	23.6	12.42
14	Тэнгэр даатгал ХХК	34.6	19.8	-14.84
15	Соёмбо даатгал ХХК	34.5	34.8	0.34
16	Монре даатгал ХХК	47.4	23.2	-24.12
17	УБ хотын даатгал ХХК	26.4	19	-7.40
	ДҮН	33.1	29.5	-3.60

Даатгалын компаниудын 2012 оны 1 дүгээр улиралд олгосон хохирол нөхөлтийн харьцааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 компанийн үзүүлэлт буурч, 4 компани буюу “Монгол даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Соёмбо даатгал” ХХК, “Нэйшнл лайф даатгал” ХХК-иудын харьцаа харгалзан 0.99, 12.42, 0.34, 6.63 пунктээр тус тус өссөн байна.

1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

2012 оны 1 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 2182.6 сая төгрөг байна.


Тайлант улиралд ердийн даатгалын 15 компани ашигтай ажилласан бөгөөд “Соёмбо даатгал” ХХК 88.4 сая төгрөг, “Нэйшнл лайф даатгал” ХХК 21.8 сая төгрөгийн тус тус алдагдалтай ажиллан нийт салбарын хэмжээний тайлант үеийн цэвэр ашгийг бууруулахад нөлөөлж байна. (Хүснэгт-10).

Даатгалын компанийн 2012 оны 1 дүгээр улирлын цэвэр ашиг (алдагдал)

	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	130.4	6.0
2	Бодь даатгал ХХК	204.2	9.4
3	Ган зам даатгал ХХК	106.3	4.9
4	Мандал женерал даатгал ХХК	42.9	2.0
5	Жонон даатгал ХХК	10.6	0.5
6	МИГ даатгал ХХК	300.6	13.8
7	Монгол даатгал ХХК	506.3	23.2
8	Гэр даатгал ХХК	14.8	0.7
9	Моннис даатгал ХХК	150.9	6.9
10	Мөнх даатгал ХХК	35.9	1.6
11	Номин даатгал ХХК	185.3	8.5
12	Нэйшнл лайф даатгал ХХК	(21.8)	-1.0
13	Практикал даатгал ХХК	201.6	9.2
14	Тэнгэр даатгал ХХК	339.1	15.5
15	Соёмбо даатгал ХХК	(88.4)	-4.1
16	Монре даатгал ХХК	46.8	2.1
17	УБ хотын даатгал ХХК	17.1	0.8
	ДҮН	2,182.6	100.0

1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 5 жилийн мөн үеийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд 2009 оны 1 дүгээр улиралд буурч 2010 оноос хойш өсч улмаар 2012 оны мөн үед 36.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.



1.9 ДАВХАР ДААТГАЛ

Давхар даатгалын хураамж 2010 оны 1 дүгээр улиралд 1124.1 сая төгрөг, 2011 оны 1 дүгээр улиралд 2795.4 сая төгрөг, тайлант оны 1 дүгээр улиралд 8057.1 сая төгрөг болж тогтвортой өссөн байна. Өмнөх оны мөн үеийнхээс 5261.7 сая төгрөгөөр буюу 2,9 дахин нэмэгдсэн байна.



Тайлант үеийн байдлаар даатгалын нийт хураамжийн орлогын 45,4 хувийг давхар даатгалд төлсөн хураамж эзэлж байна.

2012 оны 1 дүгээр улиралд төлсөн давхар даатгалд “Ард даатгал” ХХК 473.8 сая төгрөг, “Бодь даатгал” ХХК 2361.1 сая төгрөг “Мандал женерал даатгал” ХХК 292.7 сая төгрөг, “МИГ даатгал” ХХК 605.4 сая төгрөг “Монгол даатгал” ХХК 3150.4 сая төгрөг, “Номин даатгал” ХХК 6.6 сая, төгрөг, “Тэнгэр даатгал” ХХК 101.7 сая төгрөг “Нэйшнл лайф даатгал” ХХК 2.5 сая “Соёмбо даатгал” ХХК 28.2 сая төгрөг, “Ганзам даатгал” ххк 170.5 сая төгрөг, “Моннис даатгал” ХХК 836.4 сая төгрөг, “Практикал даатгал” ХХК 20.0 сая төгрөг, “Монре даатгал” ХХК 7.8 сая төгрөгийг тус тус давхар даатгалд төлсөн байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЕРДИЙН ДААТГАЛ

2.1 ЕРДИЙН ДААТГАЛ

2012 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 17 ердийн даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Ердийн даатгалын компанийн салбар 190 болсон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 51-ээр нэмэгдсэн байна.

2.2 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ

Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 17 даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 80.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд 2009 оны мөн үеэс 47.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.



2.3 ЕРДИЙН ДААТГАЛЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Эзэмшигчийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2009 оноос тогтвортой өссөн байна.

(Хүснэгт-11)

/сая төгрөгөөр/

Санхүүгийн үзүүлэлт	2011 - I		2012 - I		Өсөлт бууралт	
	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь
Эзэмшигчдийн өмч	19966.1	81.15	28514.9	75.20	8548.8	-5.94
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	4638.5	18.85	9402.2	24.80	4763.7	5.94
Эзэмшигчдийн өмчийн дүн	24604.6	100	37917.1	100	13312.5	0.00

Тайлант оны 1 дүгээр улирлын эзэмшигчдийн өмчийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 8548.8 сая төгрөгөөр, хуримтлагдсан ашиг 4763.7 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

2.4 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант үед ердийн даатгалын компаниуд 17668.4 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой ажилласан бөгөөд үүнээс 8054.6 сая төгрөг буюу 45,6 хувийг давхар даатгалд, 46.1 сая төгрөг буюу 0.4 хувийг буцаасан даатгалын хураамжид төлж, 9567.6 сая төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлоготой ажилласан байна.

Даатгалын компаниудыг 2012 оны 1 дүгээр улиралд олсон даатгалын хураамжийн орлогоор жагсаахад нийт хураамжийн орлогын 30.1 хувь буюу 5315.7 сая төгрөгийг эхний нэг компани бүрдүүлсэн бол эхний 3 компани нийт хураамжийн орлогын 59.2 хувийг бүрдүүлж байна.

(Хүснэгт-12)

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компаниуд	Даатгалын хураамжийн орлого	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	1,501.8	8.5
2	Бодь даатгал ХХК	3,363.7	19.0
3	Ган зам даатгал ХХК	205.7	1.2
4	Мандал женерал даатгал ХХК	382.7	2.2
5	Жонон даатгал ХХК	-	0.0
6	МИГ даатгал ХХК	1,779.0	10.1
7	Монгол даатгал ХХК	5,315.7	30.1
8	Гэр даатгал ХХК	9.9	0.1
9	Моннис даатгал ХХК	1,108.2	6.3
10	Мөнх даатгал ХХК	131.8	0.7
11	Номин даатгал ХХК	675.3	3.8
12	Практикал даатгал ХХК	481.9	2.7
13	Тэнгэр даатгал ХХК	882.7	5.0
14	Соёмбо даатгал ХХК	964.9	5.5
15	Монре ХХК	736.9	4.2
16	УБ хотын даатгал ХХК	128.2	0.7
	ДҮН	17,668.4	100.0

2.5 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2012 оны 1 дүгээр улирлын байдлаар 2204.4 сая төгрөгийн нөхөн төлбөр олгожээ.

“Монгол даатгал” ХХК нийт нөхөн төлбөрийн 43.5 хувь, “Тэнгэр даатгал” ХХК 7.7 хувь, “Бодь даатгал” ХХК 7.2 хувь, “Миг даатгал” ХХК 8.7 хувийг тус тус бүрдүүлж нийт зах зээлийн 67.1 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-13)
/сая төгрөгөөр/

№	Даатгалын компаниуд	Даатгалын нөхөн төлбөр	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	246.6	8.5
2	Бодь даатгал ХХК	208.6	7.2
3	Ган зам даатгал ХХК	4.8	0.2
4	Мандал женерал даатгал ХХК	1.7	0.1
5	Жонон даатгал ХХК	-	0.0
6	МИГ даатгал ХХК	254.2	8.7
7	Монгол даатгал ХХК	1,267.1	43.5
8	Гэр даатгал ХХК	0.1	0.0
9	Моннис даатгал ХХК	31.4	1.1
10	Мөнх даатгал ХХК	12.0	0.4
11	Номин даатгал ХХК	173.4	6.0
12	Практикал даатгал ХХК	171.0	5.9
13	Тэнгэр даатгал ХХК	225.4	7.7
14	Соёмбо даатгал ХХК	230.5	7.9
15	Монре даатгал ХХК	49.8	1.7
16	УБ хотын даатгал ХХК	33.5	1.2
	ДҮН	2,910.1	100.0

2.6 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРОЛ НӨХӨЛТИЙН ХАРЬЦАА

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй ердийн даатгалын компаниудын даатгалын хохирол нөхөлтийн харьцааг авч үзэхэд 2012 оны 1 дүгээр улирлын байдлаар “Монгол даатгал” ХХК 45.7 хувь “Соёмбо даатгал” ХХК 34.8 хувь, “Номин даатгал” ХХК 31.5 хувьтай буюу хамгийн өндөр хувьтай байна.

(Хүснэгт-14)

/сая төгрөгөөр

№	Ердийн даатгагчийн нэрс	Хохирол нөхөлтийн түвшин
1	Ард даатгал ХХК	24.5
2	Бодь даатгал ХХК	21.5
3	Ган зам даатгал ХХК	4.1
4	Мандал женерал даатгал ХХК	1.2
5	Жонон даатгал ХХК	0.0
6	МИГ даатгал ХХК	24.9
7	Монгол даатгал ХХК	45.7
8	Гэр даатгал ХХК	3.5
9	Моннис даатгал ХХК	17.7
10	Мөнх даатгал ХХК	5.9
11	Номин даатгал ХХК	31.5

12	Практикал даатгал ХХК	23.6
13	Тэнгэр даатгал ХХК	19.8
14	Соёмбо даатгал ХХК	34.8
15	Монре даатгал ХХК	23.2
16	УБ хотын даатгал ХХК	18.97304
	ДҮН	29.44439

2.7 ЕРДИЙН ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 2204.4 сая төгрөг бөгөөд ердийн даатгалын компаниуд нэгдсэн дүнгээр ашигтай ажилласан байна.

(Хүснэгт-15)

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	130.4	5.9
2	Бодь даатгал ХХК	204.2	9.3
3	Ган зам даатгал ХХК	106.3	4.8
4	Мандал генерал даатгал ХХК	42.9	1.9
5	Жонон даатгал ХХК	10.6	0.5
6	МИГ даатгал ХХК	300.6	13.6
7	Монгол даатгал ХХК	506.3	23.0
8	Гэр даатгал ХХК	14.8	0.7
9	Моннис даатгал ХХК	150.9	6.8
10	Мөнх даатгал ХХК	35.9	1.6
11	Номин даатгал ХХК	185.3	8.4
12	Практикал даатгал ХХК	201.6	9.1
13	Тэнгэр даатгал ХХК	339.1	15.4
14	Соёмбо даатгал ХХК	(88.4)	-4.0
16	Монре ХХК	46.8	2.1
17	УБ хотын даатгал ХХК	17.1	0.8
	ДҮН	2,204.4	100.0

2.8 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН

2012 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын нөөц сангийн үлдэгдлийн 29.2 хувийг учирч болзошгүй хохирлын нөөц сан, 50.3 хувийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан, 0.3 хувийг нэхэмжилсэн хохирлын нөөц, 17.8 хувийг учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан, 2.4 хувийг тусгайлсан нөөц сангууд эзэлж байна.

(Хүснэгт-16)

/сая төгрөгөөр/

Нөөц сан	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан	18527.1	8258.8	8658.7	18127.2
Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	5820.3	1864.6	1265.6	6419.3
Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	74.5	2824.6	2806.5	92.5
Учирч болзошгүй нөөц сан	9398.0	1327.7	181.8	10543.9
Тусгайлсан нөөц сан	2813.2	-	1953.2	859.9
ДҮН	36633.1	14275.7	14865.9	36042.9

2012 оны 1 дүгээр улирлын байдлаар тусгайлсан нөөц санг хааж 2012 оны эхний үлдэгдэлгүй болгох талаар ердийн даатгалын компаниудад шаардлага өгсөн байна. Үүнтэй холбоотой дийлэнх компаниуд тусгайлсан нөөц сангийн үлдэгдлийг хаасан байна.

2.9 ЕРДИЙН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ

2012 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 8054.6 сая төгрөгийг давхар даатгалд төвлөрүүлсэн байна. “Бодь даатгал” ХХК 29.31 хувь, “Монгол даатгал” ХХК 39.11 хувийг тус тус эзэлж нийт давхар даатгагчид төвлөрүүлсэн хөрөнгийн 68.42 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-17) /сая төгрөгөөр/

№	Даатгагчийн нэр	Давхар даатгалын хураамжийн орлого	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	473.8	5.88
2	Бодь даатгал ХХК	2361.1	29.31
3	Тэнгэр даатгал ХХК	101.7	1.26
4	Практикал даатгал ХХК	20	0.25
5	Миг даатгал ХХК	605.4	7.52
6	Монгол даатгал ХХК	3150.4	39.11
7	Номин даатгал ХХК	6.6	0.08
8	Мандал женерал даатгал ХХК	292.7	3.63
9	Соёмбо даатгал ХХК	28.2	0.35
10	Ган зам даатгал ХХК	170.5	2.12
11	Моннис даатгал ХХК	836.4	10.38
12	Монре даатгал ХХК	7.8	0.10
	Дүн	8054.6	100.00


ГУРАВДУГААР БҮЛЭГ.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

3.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Даатгалын зах зээл дээр “Нэйшнл лайф даатгал” ХХК нь урт хугацааны даатгалын үйл ажиллагааг 2008 оноос хойш явуулж байна.

Тус компанийн хөрөнгийн хэмжээ 2010 оны 01 дүгээр улирлын байдлаар 1105.1 сая төгрөг, 2011 оны мөн үеийн байдлаар 2078.1 сая төгрөг 2012 оны мөн үеийн байдлаар 3560.0 сая төгрөгт хүрч, жил бүр нэмэгдэж ирсэн байна. /График-9 /

/сая төгрөгөөр/



Хорооны 2011 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор тус компанийн дүрмийн сангийн хэмжээг 3.5 тэрбум болгон нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн.

3.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, ДАВХАР ДААТГАЛ, ДАВХАР ДААТГАЛ

Урт хугацааны даатгалын компани 2012 оны 1 дүгээр улирлын байдлаар 98.9 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой ажиллаж, 2.5 сая төгрөгийг давхар даатгагчид төвлөрүүлж, 41.4 сая төгрөгийг даатгалын нөхөн төлбөрт төлжээ. Сүүлийн 2 жилийн мөн үеийн байдлаар орлого, давхар даатгал, нөхөн төлбөрийн үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулбал:

(Хүснэгт-19) /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2011-1	2012-1	Өөрчлөлт
Хураамжийн орлого	43.2	98.9	55.7
Давхар даатгал	7.2	2.5	-4.7
Нөхөн төлбөр	9.5	41.4	31.9

Өмнөх оны мөн үеийнхээс хураамжийн орлого 55.7 сая төгрөгөөр, нөхөн төлбөр 31.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, давхар даатгал 4.7 сая төгрөгөөр буурсан байна.

3.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА, НӨӨЦ САН

Урт хугацааны даатгагч нь 2008 оноос хойш алдагдалтай ажилласаар ирсэн бөгөөд нийт хуримтлагдсан алдагдлын хэмжээ 668.5 сая төгрөгт хүрсэн байна.

(Хүснэгт-20) /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2011-1	2012-1	Өөрчлөлт
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-539.8	-668.5	128.7
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-65.2	-21.8	-43.4
Нөөц сан	109.7	313.8	204.1

Өмнөх оны мөн үеийнхээс хуримтлагдсан алдагдал 128.7 сая төгрөгөөр, нөөц сан 204.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

(Хүснэгт-21) /сая төгрөгөөр/

Даатгалын нөөц	2011-1	2012-1	Өөрчлөлт
Хувь оролцоотой гэрээний нөөц сан			
Хувь оролцоогүй гэрээний нөөц сан	109.7	313.8	204.1
Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан			
ДҮН	109.7	313.8	204.1

Нөөц сан 2012 оны 1 дүгээр улирлын байдлаар 313.8 сая төгрөг байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 204.1 сая төгрөгөөр өссөн байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

4.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

Тайлант оны 1 дүгээр улиралд нийт 10 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн байна. Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 137.4 сая төгрөг болсон ба үүнээс 87.8 хувь буюу 120.7 сая төгрөгийг даатгалын зуучлалын үйл ажиллагааны орлого эзэлж байна.

(Хүснэгт-21)
/сая төгрөгөөр/

/сая төгрөгөөр/

№	Компанийн нэр	Даатгалын зуучлалын орлого		Өөрчлөлт
		2011-1	2012-1	
1	“Асимон брокерс” ХХК	5.9	8.9	3.00
2	“АМЕ” ХХК	6.9	67.1	60.20
3	“Ачит ундарга” ХХК	8.4	10.6	2.20
4	“Лоялти солюшн” ХХК	4	10.4	6.40
5	“Эм Жи Ай Би” ХХК	0	4.5	4.50
6	“Юу ай би” ХХК	0	0	-
7	“Ренессанс групп” ХХК	8.8	17.1	8.30
8	“Жомолхари” ХХК	0	2.1	2.10
9	“Монголиан интернэшнл брокерс” ХХК	13.5	0	(13.50)
10	“Нэйшнл эженси” ХХК	0	0	-
	Нийт дүн	47.5	120.7	73.2

Тайлант оны зуучлалын орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Аме” ХХК 60.2 сая төгрөгөөр, “Лоялти солюшн” ХХК 6.4 сая төгрөгөөр, “Ачит ундарга” ХХК 2.2 сая төгрөгөөр, “Ренессанс групп” ХХК 8.3 сая төгрөгөөр, “Жомолхари” ХХК 2.1 сая төгрөгөөр, , “Эм жи ай би” ХХК 4.5 сая төгрөгөөр Асимон брокерс” ХХК 3.0 сая төгрөгөөр тус тус өссөн байна. “Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Нэйшнл эженси” ХХК, “Юу ай би” ХХК-иуд үйл ажиллагааны орлого төвлөрүүлж ажиллаагүй байна.

“Аме” ХХК нь нийт даатгалын зуучлалын үндсэн үйл ажиллагааны орлогын 60.2 хувийг дангаараа эзэлсэн байна.

4.3 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 40.2 сая төгрөг болсон байна. Үүнээс даатгалын хохирол үнэлэгчийн орлого нийт орлогын 49.5 хувь буюу 19.9 сая төгрөг төвлөрүүлж, үлдсэн 50.5 хувийг бусад орлого эзэлж байна.

(Хүснэгт-22)
/сая төгрөгөөр/

№	Компанийн нэр	Даатгалын хохирол үнэлгээний орлого		Өөрчлөлт
		2011-1	2012-1	
1	“Бест эстимэйт” ХХК	1.6	1.7	0.10
2	“Гэрэгэ эстимэйт” ХХК	2.2	6.1	3.90
3	“Файн эстимэйт” ХХК	0	0.2	0.20
4	“Итгэлт эстимэйт” ХХК	3.8	0	
5	“Мега марз” ХХК	0.9	0	
6	“Вендо” ХХК	3.6	6.7	3.10
7	“Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК	0.06	0.03	
8	"Арвижих эстимэйт" ХХК		4.7	4.70
9	"Жи ай си си" ХХК		0.5	0.50
	Нийт дүн	12.16	19.93	7.3

2011 оны тайлант үеийн хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Гэрэгэ эстимэйт” ХХК 3.9 сая төгрөгөөр, “Вендо” ХХК 3.10 сая төгрөгөөр, “Файн эстимэйт” ХХК 0.2 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Тайлант хугацаанд “Мега марз” ХХК, “Итгэлт эстимэйт” нь санхүүгийн тайлангаа ирүүлээгүй байна.

XI. ДҮГНЭЛТ

Даатгалын зах зээл дээр 2012 оны 1 дүгээр улиралд үйл ажиллагаа явуулсан даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид нийт 17944.9 сая төгрөгийн орлого олсон байна. Энэхүү орлогын 17668.4 сая төгрөг буюу 98.5 хувийг ердийн даатгалын компаниуд, 98.9 сая төгрөг буюу 0.5 хувийг урт хугацааны даатгалын компани, 137.4 сая төгрөг буюу 0.8 хувийг даатгалын зуучлагч компаниуд, 40.2 сая төгрөг буюу 0.2 хувийг даатгалын хохирол үнэлэгч компаниудын олсон орлого тус тус бүрдүүлсэн байна.

2012 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын зах зээл дээр урт хугацааны болон ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын нийт хөрөнгө 84.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 26.0 тэрбум төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн байна.

Түүнчлэн тайлант үеийн цэвэр ашиг 2.2 тэрбум төгрөгт хүрсэн ба даатгалын байгууллагууд салбарын хэмжээнд ашигтай ажиллаж байгаа нь аливаа эрсдлийг даван туулах хандлага, чадвар нэмэгдэж байна гэж дүгнэхээр байна.

Даатгалын компаниуд өөрсдийн хүлээж буй болзошгүй даатгалын томоохон эрсдлийг давхар даатгагчид шилжүүлсэн байдал өмнөх оны мөн үеийнхээс 2.9 дахин өссөнийг эрсдлээ шилжүүлэх шаардлага, хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаагаар тайлбарлаж болох юм.

Даатгалын салбарын 2012 оны 1 дүгээр улирлын нэгдсэн үзүүлэлтүүдийг өмнөх жилүүдийн үзүүлэлтүүдтэй харьцуулж үзэхэд даатгалын зах зээлийн өсөлт, тэлэлт явагдаж байгааг харж болохоор байна. Улс орны эдийн засгийн өсөлт, эрхзүйн шинэ зохицуулалт нь даатгалын эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх шинэ хүчин зүйл болж байна.

Нөгөө талаас зарим сөрөг үзүүлэлтүүд ажиглагдаж байгаа ба тухайлбал, даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид эзлэх даатгалын нөөц сангийн хувийг авч үзэхэд 2008 оны 1 дүгээр улиралд 63,0 хувийг эзэлж байсан бол 2009 оны 1 дүгээр улиралд 43,0 хувь, 2010 оны 1 дүгээр улиралд 58,5 хувь, 2011 оны 1 дүгээр улиралд 49,5 хувь, 2012 оны мөн үед 44.1 хувь болж тус тус буурсан байна. Даатгалын компанийн балансын нийт пассивт нөөц сангийн эзлэх хувь 2010 оноос хойш буурч, харин эзэмшигчийн өмчийн эзлэх хувь өссөн бөгөөд энэ нь нэг талаас хувь нийлүүлэгчийн хөрөнгө буюу дүрмийн сангийн өсөлт, нөгөө талаас даатгалын нөөц сангийн актуар тооцоолол хангалтгүй байгаатай холбоотой.

Даатгалын компаниудын нийт хөрөнгөнд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, хөрөнгө оруулалтууд ихээхэн хувийг эзэлж байгаа нь даатгагчийн урт хугацаан дахь хөрөнгө оруулалтын өгөөжид сөргөөр нөлөөлөх хандлагатай байна.

ДААТГАЛЫН ГАЗРЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС